

“Mongolian Studies/Монгол Судлал” сэтгүүлд Эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авна

Хирошима Их сургуулийн “Монгол судлалын төв”-өөс эрхлэн гаргадаг “Mongolian Studies /Монгол Судлал” сэтгүүл нь 2020 оны 3-р сард анхны дугаараа хэвлүүлэн, олон орны судлаачид судалгааны өгүүлээ нийтлүүлсэн билээ.

Энэ удаад тус сэтгүүлийн 3 дахь дугаарыг 2022 оны 3 сард хэвлүүлэхтэй холбогдуулан эрхэм судлаач та бүхнийг эрдэм шинжилгээний өгүүлэлээ ирүүлэхийг урьж байна.

Уг сэтгүүлд Монгол судлалын хүрээнд хийгдсэн хэл шинжлэл, уран зохиол, боловсрол, сэтгэл судлал, заах арга, соёл, түүх, нийгэм, угсаатны зүй, гүн ухаан, шашин судлалын чиглэлийн өгүүлэлийг хүлээн авч, сэтгүүлийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн хянасны дагуу хэвлэлтэнд сонгох эсэх талаар шийдвэрлэнэ.

Сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл нь Судлаачийн өөрийн хийсэн судалгаанд үндэслэн бичигдсэн байхын зэрэгцээ бусад сэтгүүлд нийтлэгдээгүй шинэлэг бүтээл байхыг гол шаардлага болгоно.

Өгүүллийг монгол, япон, англи хэлний аль нэгийг сонгон бичиж болно.

Өгүүлэл хүлээн авах сэтгүүл:

“Mongolian Studies/Монгол Судлал”№2

Өгүүлэл хүлээн авах сүүлийн хугацаа:

2021.12.31 (өдөр 12:00 цаг хүртэл)

Өгүүлэл хүлээн авах E-mail хаяг:

admin@huusumrc.hiroshima-u.ac.jp

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих журам:

Бичвэрийн үсгийн формат

Өгүүллийг А4 хэмжээтэйгээр нийт 10 хуудсанд багтаасан байна. Монгол, англи хэлээр бичих тохиолдолд Word программ ашиглан Times New Roman фонтод тохируулж, 12 pt үсгээр бичсэн байна.

Бичвэр нь хуудсан дээр байрлахдаа дээд доод талаасаа тус бүр 3 см, баруун зүүн талаасаа тус бүр 3 см зай авсан байна. Мөр хоорондын зай 1см байна. Шинэ мөрийг зүүн талаасаа нэг үсгийн хэмжээний зайтай эхлүүлнэ. Хуудасны дугаарыг Header цэсээр идэвхжүүлсэн мөрөнд баруун үзүүрт нь араб тоогоор бичнэ.

Өгүүллийн сэдэв 14 pt хэмжээтэй, Bold тохируулгатай, нийтэд нь том үсгээр бичнэ. Дэд гарчиг байгаа тохиолдолд 12 pt хэмжээтэй, Bold тохируулгатай, эхний үсгийг томоор эхэлж бусдыг нь жижгээр бичнэ. Бүлэг бүрийн нэрийг 12 pt хэмжээтэй, эхний үсгийг томоор эхэлж бусдыг нь жижгээр бичнэ.

Бичвэр дотор Ишлэл татаж оруулахдаа агуулгыг “ ” хаалтанд бичиж, ард нь / / хаалтанд

ишлэлийн эх сурвалжийн талаар (зохиогчийн нэр, хэвлэгдсэн он, иш татсан хуудас) бичнэ.

Зүүлт хийхдээ хуудасны доод талд Footer цэсээр идэвхжүүлсэн мөрөнд үсгийн хэмжээ 11 pt, эхлэл тал буюу зүүн үзүүрт ишлэлийн дугаар, түүнээс нэг үсгийн зайтай зүүлтийн дэлгэрэнгүйг болон эх сурвалжийг бичнэ.

Өгүүлэлд оруулах хүснэгт, схем, зураг зэрэгт дарааллаар нь дугаар хийн, өгөгдлийн дээд хэсэгт дугаар, нэрийг бичиж, доод хэсэгт нь эх сурвалжийг нэр, оны хамт бичнэ.

Номзүй дэх номын жагсаалтыг 12 pt хэмжээтэй үсгээр, сонгосон хэлний цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Олон хэлнээс ашигласан тохиолдолд хэл тус бүрээр нь нэгтгэж жагсаана.

Өгүүллийн ерөнхий бүтэц (агуулга)

- Өгүүллийн сэдэв

-Дэд сэдэв- (*Дэд сэдэв байхгүй тохиолдолд оруулахгүй байж болно*)

- Зохиогчийн овог нэр

Харьяалал, Эрдмийн цол зэрэг

Холбоо барих E-mail хаяг

- Хураангуй (*Өгүүлэл бичигдсэн хэлээр нийт 10 хүртэлх мөрөнд багтаан бичнэ.*)

- Түлхүүр үг (*нийтдээ 3-5 үг*)

- Удиртгал

- Бүлгийн гарчиг (*Бүлэг нь агуулгаасаа шалтгаалан хэд хэдэн хэсэгт хуваагдаж болно.*

Мөн бүлэг тус бүрийг дотор нь дэлгэрүүлэн Дэд бүлгүүдээс бүрдүүлэх боломжтой бөгөөд тус бүрийг хэсэг бүрээр нь тусгаарлан дугаарлана.)

1.

1.1

1.2

2.

2.1

2.1.1

- Дүгнэлт

- Ном зүй (*Ашигласан номын жагсаалтад зөвхөн уг өгүүлэлд иш татсан ном болон бусад материалын нэрсийг тухайн хэлний цагаан толгойн үсгийн дарааллаар оруулна*)

Номзүй бичих загвар:

Bach, Emmon and Robert T. Harms (eds.) (1968) *Universals in linguistic theory*.

New York: Holt, Rinehart and Winston.

Langacker, Ronald W. (1993a) Grammatical traces of some “invisible” semantic constructs. *Language Sciences* 15: 323-355.

- Хавсралт (*Хавсралт материал нийт 3 хуудаснаас ихгүй байна.Хавсралт байхгүй тохиолдолд оруулахгүй байж болно.*)
- Title, Name, Affiliation, Abstract (*Өгүүллийн сэдэв, Өгүүллийн Хураангуй,Зохиогчийн овог нэр, Зохиогчийн ажилын харьяалал зэргийг өгүүлэл бичигдсэн хэлнээс гадна англи хэлээр мөн бичиж ирүүлнэ үү.*)

Өгүүлэл хүлээн авах талаар:

Өгүүллийг admin@huusumrc.hiroshima-u.ac.jp хаягаар E-mail-д хавсарган файлаар ирүүлэх бөгөөд хүлээн авсан өгүүллийг тус сэтгүүлийн эрдмийн зөвлөл хэлэлцэн хянаснаар дараах шийдвэрийн дагуу Зохиогчийн E-mail хаягаар хариу мэдэгдэн харилцана.

a/ Тухайн өгүүллийг тус сэтгүүлд хэвлэх боломжтой эсэх (Accept or Reject) талаар

b/ Хэвлэхээр шийдэгдсэн тохиолдолд, Эрдэм шинжилгээний Өгүүлэл (Article) ,

Судалгааны Тэмдэглэл (Research note) зэргийн аль хэлбэрээр хүлээн авах тухай

c/ Түүнчлэн шаардлагатай тохиолдолд засан сайжруулах санал зөвлөмж илгээх зэрэг

Жич:

Зохиогчийн ажил мэргэжил, төгссөн буюу эрдмийн ажил хамгаалсан сургууль, удирдагч багш, эрдмийн цол зэргэм, эрдмийн ажил болон ном бүтээлийн тойм жагсаалт зэргийг голлон дурьдсан Товч намтарыг 2 хүртэлх хуудсанд багтаан бичиж, өгүүллээс тусад нь ирүүлнэ үү. Монгол болон англи, япон хэлээр байж болно.